



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 185


Улаанбаатар  
хот

Импортын зарим барааны гаалийн  
албан татварын хувь, хэмжээг  
тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-ний 04, 07, 21, 39, 44, 49, 51, 56, 61, 63, 64, 68, 69, 94 дүгээр бүлэгт заасан зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.




Монгол Улсын Ерөнхий сайд

Аж үйлдвэрийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Д.ЭРДЭНЭБАТ



Засгийн газрын 2016 оны 185 дугаар  
тогтоолын хавсралт

**ИМПОРТЫН ЗАРИМ БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН  
ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Бүлэг	Зүйл	Үндэсний код	Барааны бичиглэл	Одоо мөрдөж буй албан татвар	Албан татварыг нэмэгдүүлэх хувь, хэмжээ
04	04.01		Саахар болон бусад амтлагчийн хольцгүй, шингэн сүү, цөцгий	5%	15%
	04.03		Саахар, эсхүл бусад чихэрлэг амтлагч, үнэр оруулагч, жимс, самар, эсхүл какаогийн хольцтой, эсхүл хольцгүй, өтгөрүүлсэн, эсхүл өтгөрүүлээгүй зөөхий, йогурт, тараг, хоормог, ферментжүүлсэн, эсхүл исгэсэн бусад сүү болон цөцгий	5%	15%
	04.04	0404.10.00	- Саахар, эсхүл бусад чихэрлэг амтлагчийн хольцтой, эсхүл хольцгүй, өтгөрүүлсэн, эсхүл өтгөрүүлээгүй шар сүү, хувиргасан шар сүү	5%	20%
	04.05		Цөцгийн тос, сүүнээс гаргаж авсан бусад өөх тос; өтгөн цөцгий	5%	15%
	04.06		Бяслаг ба аарц	5%	15%
	07	07.01		Шинэ, эсхүл хөргөсөн төмс	15%
07.02			Шинэ, эсхүл хөргөсөн улаан лооль	5%	20%
07.03		0703.90.00	- Ногоон сонгино болон сонгины төрлийн бусад ногоо	5%	15%
07.04		0704.90.10	--- Бөөрөнхий байцаа	15%	20%
07.06		0706.10.10	--- Шар лууван	15%	20%
		0706.10.20	--- Шар манжин	15%	20%
07.07		0707.00.00	Шинэ, эсхүл хөргөсөн урт өргөст хэмх болон давжаа хэмх	5%	20%
07.10		0710.10.00	- Төмс	5%	20%
21	21.05	2105.00.00	Какао агуулсан, эсхүл агуулаагүй зайрмаг, хүнсний зориулалтын бусад мөсөн бүтээгдэхүүн	5%	15%
39	39.25		Барилгын зориулалттай, бусад газар заагдаагүй хуванцар зүйлс		
		3925.20.10	--- Хаалга	5%	6.5%
		3925.20.20	--- Цонх	5%	6.5%
44	44.12	4412.94.00	-- Блокон хавтан, давхарлаж наасан хавтан, савхалсан хавтан	5%	10%
			- Хаалга, хаалганы хүрээ мод, босго:		
		4418.20.10	--- Хаалга	5%	20%
		4418.20.20	--- Хаалганы хүрээ, босго	5%	20%
49	49.10	4910.00.00	Бүх төрлийн хэвлэмэл хуанли (гасалбар хуанли орно).	5%	20%
	49.11	4911.10.00	- Худалдааны зар сурталчилгааны материал болон барааны каталог, түүнтэй төстэй бусад материал	5%	20%

51	51.06		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл	5%	10%
	51.07		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины самнасан ноосон ээрмэл	5%	10%
	51.08		Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, мал, амьтны нарийн үс, ноосон сэмлэсэн, эсхүл самнасан ээрмэл	5%	10%
56	56.02	5602.10.00	- Шивсэн эсгий, мяндсыг нь өөр хооронд нь хэрсэн бүтээгдэхүүн	5%	10%
		5602.21.00	-- Хонины ноос, эсхүл мал, амьтны нарийн үс, ноосон	5%	20%
61	61.14	6114.90	Нэхмэлийн бусад материалан	5%	20%
63	63.05	6305.32.00	-- Дамжлагын бөөний савлагааны зориулалттай, их даацын уян шуудай	5%	20%
64	64.03	6403.40.00	- Хамар нь металл хамгаалалттай бусад гутал	5%	20%
68	68.06	6806.10.10	--- Эрдэс чулуун хөвөн	5%	15%
		6806.10.60	--- Шаарган хөвөн	5%	15%
	68.10	6810.11.10	--- Барилгын блок (хөнгөн бетон гулдмай орно)	5%	15%
		6810.11.20	---- Силикат тоосго	5%	10%
		6810.19.10	-- Зам талбайн бетонон хашлага	5%	20%
		6810.19.20	-- Зам талбайн бетонон хавтан	5%	15%
		6810.91.30	--- Барилгын ханын төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.40	--- Барилгын тааз, дээврийн төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.50	--- Инженерийн байгууламжийн төмөр-бетон бүтээц, хийц хэсэглэл	5%	20%
		6810.91.60	--- Төмөр-бетон шат, гишгүүр	5%	20%
		6810.91.70	--- Төмөр замын бетонон дэр	5%	20%
	6810.91.90	--- Барилгын бусад угсармал хийц, хэсэглэл		20%	
69	69.04	6904.10.00	- Барилгын тоосго	5%	20%
94	94.03	9403.30.00	- Албан газрын зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.40.00	- Гал тогооны өрөөний зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.50.00	- Унтлагын өрөөний зориулалттай модон тавилга	5%	20%
		9403.60.00	- Бусад модон тавилга	5%	20%